

# Хүний хувийн мэдээллийг хамгаалах нь

Төрийн байгууллагад зориулсан гарын  
авлага

2023 он



# Агуулга

<b>01</b>	Товч мэдэгдэл	1
<b>02</b>	Гарын авлагын тухай	2
<b>03</b>	Хүний хувийн мэдээллийн тухай ойлголт	3
<b>04</b>	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль	4
<b>05</b>	Хүний хувийн мэдээлэл гэж юу вэ?	5
<b>06</b>	Хүний эмзэг мэдээлэл болон нууц гэж юу вэ?	6
<b>07</b>	Хүний хувийн мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах	7
<b>08</b>	Нийтийн мэдээлэл түүний ангилал ба нийтийн мэдээлэл хариуцагч	8
<b>09</b>	Нээлттэй, ил тод байлгах хүний хувийн мэдээллийн талаар мэдэх нь	9
<b>10</b>	Төрийн байгууллага хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах харилцаа	10
<b>11</b>	Төрийн байгууллага хүний хувийн мэдээллийг хамгаалахад анхаарах 8 асуудал	11
<b>12</b>	Хураангуй зөвлөмж	20

## **Хүний хувийн мэдээллийг хамгаалах нь (Гарын авлага, 2023)**

Зохиогчийн эрх © 2023 НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

Монгол улс, Улаанбаатар хот

Энэхүү гарын авлагыг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Бизнес ба Хүний эрх Азийн хөтөлбөрийн хүрээнд **Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын** санаачилга, оролцоотойгоор **ПрайсуотэрхаусКүүпэрс** компаниас бэлтгэсэн болно. Тус гарын авлагыг зөвхөн хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар ерөнхий ойлголт, мэдээллийг өгөх зорилгоор бэлтгэсэн бөгөөд энд тусгагдсан мэдээллийг мэргэжлийн зөвлөгөөтэй адилтгаж болохгүй юм. Иймд эрх зүйн үр дагавар бүхий тухайлсан шийдвэр гаргахдаа мэргэжлийн зөвлөгөө авахыг зөвлөж байна. Гарын авлагад үндэслэн хийсэн таны аливаа үйлдэл, эс үйлдэхүйд бид хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү гарын авлага нь зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлэхгүй. Энэхүү гарын авлагад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү гарын авлагыг 2023 оны 9 дүгээр сард боловсруулсан тул түүнээс хойш гарсан эрх зүйн актуудыг нэмж судлах шаардлагатайг анхаарна уу.

### **Хүний эрхийн Үндэсний Комисс**

Монгол Улс, Улаанбаатар 15170,  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-2,  
Засгийн газрын 12 дугаар байр  
Утас: +976 7000 0222  
<https://www.nhrcom.gov.mn>

### **НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр**

Монгол Улс, Улаанбаатар 14201,  
Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж-14,  
Нэгдсэн Үндэстний Байгууллага  
Утас: +976 1132 7585  
<https://www.undp.org/mongolia>

### **ПрайсуотэрхаусКүүпэрс Монгол (PwC)**

Монгол Улс, Улаанбаатар 14100,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Сэнтрал Тауэр, 6 давхарт 601  
Утас: +976 7000 9089  
<https://www.pwc.com/mn>

# Гарын авлагын тухай

Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах нь улам чухал болсоор байна. Дэлхийн улс орнууд хүний хувийн мэдээллийн нууцлал хамгаалалтын тухай хууль тогтоомж баталж, энэ чиглэлээр хурдацтай өөрчлөлтийг хийж байна. Эдгээр хууль тогтоомж нь хүний хувийн мэдээллийг зөвхөн тодорхой зорилгоор, эсвэл хуульд заасан үндэслэлээр цуглуулж, боловсруулж, ашиглахын зэрэгцээ мэдээллийг хамгаалахын тулд шаардлагатай арга хэмжээг авах, холбогдох дүрэм журмыг батлах зэрэг олон шаардлагыг тухайн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигласан этгээдэд тавих болжээ.

Монгол Улсын хувьд ч энэхүү шаардлагыг хуульчлан 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “**Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай**” хуулийг баталсан. Тус хууль нь 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.



Иймд байгууллагууд энэхүү өөрчлөлтөд дасан зохицож, өөрсдийн үйл ажиллагаа болон дүрэм журмаа сайжруулах шаардлага бий болж байна.

Энэ гарын авлагыг хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахтай холбоотойгоор төрийн байгууллагуудад тавигдаж буй **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн** шаардлагуудыг ойлгох, тэдгээрийг мөрдөх явдлыг хялбарчлах зорилгоор бэлтгэсэн болно. Дээрхээс гадна гарын авлагад одоогийн практикийг үнэлэх, сайжруулахад шаардлагатай мэдээлэл болон бусад улс оронд хэрэгжүүлж буй сайн туршлагад үндэслэсэн зарим анхаарах асуудлыг тусгасан.

Энэхүү гарын авлага нь төрийн байгууллагад зориулагдсан болно.

# Хүний хувийн мэдээллийн тухай ойлголт




Хүний хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал (“МНАБ”) нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн салшгүй хэсэг бөгөөд энэ хүрээнд хүмүүс өөрийн хувийн мэдээллийг нууцлах, хамгаалуулах, цаашлаад ямар хувийн мэдээллийг нь хэн цуглуулж, хэрхэн ашиглаж байгааг мэдэх болон хуульд заасны дагуу өөрийн мэдээллийг устгуулах буюу мартагдах эрхтэй юм.

Түүнчлэн, МНАБ-ыг хамгаалах асуудал нь зөвхөн хувь хүн өөрийнхөө мэдээллийг хамгаалахаар хязгаарлагдахгүй. Хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж буй этгээд ч мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу МНАБ-ыг хангаж, ёс зүйтэй хандах ёстой.

Сүүлийн жилүүдэд томоохон компаниуд МНАБ-ын зөрчил гаргасны улмаас их хэмжээний торгууль төлсөн олон тохиолдол гарах болсноор олон нийтийн зүгээс МНАБ-д ихээхэн анхаарал хандуулах болсон.

2021 оны байдлаар дэлхийн улс орнуудын 71% буюу нийт 137 улс МНАБ-ын талаар тусгайлсан хууль баталсан байна.



Монгол Улс 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсноор Хувь хүний нууцын тухай хууль хүчингүй болсон. Хувь хүний нууцын тухай хуультай харьцуулахад **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль** нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг илүү өргөн хүрээгээр баталгаажуулж, нарийн зохицуулалтыг бий болгосон.

Түүнчлэн, **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь** Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуультай харилцан уялдаатай үйлчилж, Монгол Улсад кибер аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах цогц тогтолцоог бүрдүүлж байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар 2023 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр дараах журам, шаардлагууд батлагдсан. Энэ нь:

- Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам;
- Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам.

Харин дараах шаардлага, журмууд өнөөдрийн байдлаар хараахан батлаагүй төслийн шатанд байна.

- Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээллийн журам;
- Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага.


# Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль

## Цахим хөгжлийг дэмжих багц хуулиуд

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай
- Кибер аюулгүй байдлын тухай;
- Цахим гарын үсгийн тухай хууль.



## Хуулийн үйлчлэх хүрээ



### ХУУЛИЙН БҮТЭЦ

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах;
- Мэдээллийн эзний эрх, үүрэг;
- Мэдээлэл хариуцагч болон Мэдээлэл боловсруулагч;
- Мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа;
- Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага;
- Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем.

### ЯМАР ХАРИЛЦАА?

- Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцаа;
- Техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцаа.

### ХАМААРАХГҮЙ

- Өөрт нь буюу түүний гэр бүлийн гишүүнд хамааралтай мэдээлэл;
- Хүн өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, өөрийн болон гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор:
  - ✓ дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулах;
  - ✓ өөрийн биометрик мэдээллийг ашиглах.
- Мэдээллийг нийтэд ил болгохоор хуульд заасан;
- Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулсан харилцаа;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахтай холбогдсон харилцаа.

# Хүний хувийн мэдээлэл гэж юу вэ?



**ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ** гэдэгт ямар мэдээлэл хамаарахыг улс орнууд тус тусын хуулиараа тодорхойлсон байдаг. Харин манай улсын хувьд дараах мэдээллийг хүний хувийн мэдээлэл гэж тодорхойлсон. Эдгээр нь:

ХҮНИЙ ҮНДЭС УГСАА	ШАШИН ШҮТЛЭГ, ИТГЭЛ ҮНЭМШИЛ	ЭРҮҮЛ МЭНД	ЗАХИДАЛ ХАРИЛЦАА
ЭЦЭГ ЭХИЙН БА ӨӨРИЙН НЭР	ТӨРСӨН ОГНОО, ГАЗАР	ХӨРӨНГӨ	БОЛОВСРОЛ
ГИШҮҮНЧЛЭЛ	ЦАХИМ ТОДОРХОЙЛОГЧ	ОРШИН СУУГАА ХАЯГ БАЙРШИЛ	ТООН ГАРЫН ҮСГИЙН ХУВИЙН ТҮЛХҮҮР
ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ДУГААР	ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ЭСВЭЛ ЭДЭЛСЭН ЭСЭХ	ГЕНЕТИК МЭДЭЭЛЭЛ	БИОМЕТРИК МЭДЭЭЛЭЛ

**БЭЛГИЙН БА ХҮЙСИЙН ЧИГ БАРИМЖАА, ИЛЭРХИЙЛЭЛ, БЭЛГИЙН ХАРЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ**



## ХҮНИЙГ **ШУУД** ТОДОРХОЙЛСОН, ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖТОЙ МЭДЭЭЛЭЛ

Тухайн мэдээллийг ашиглан тодорхой нэг хүнийг шууд тодорхойлох. **Жишээ нь:** регистрийн дугаар, цахим шуудан г.м.

## ХҮНИЙГ **ШУУД БУСААР** ТОДОРХОЙЛСОН, ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖТОЙ МЭДЭЭЛЭЛ

Олон эх сурвалжаас авсан өөр өөр мэдээллийг нэгтгэх замаар тухайн хүнийг тодорхойлох. **Жишээ нь:** ажилтны үнэмлэхийн дугаар, машины дугаар г.м.

## Цахим тодорхойлогч гэж юу вэ?

Хүнийг цахим орчинд тодорхойлох мэдээллийн системийн нэвтрэх нэр, цахим шуудан, нийгмийн сүлжээ, харилцаа холбооны утастай болон утасгүй технологийн хаяг, бусад төрлийн төхөөрөмж, мэдээллийн систем дэх мэдээлэл.

**Жишээлбэл:** “Хүний цахим шуудангийн хаяг, фейсбүүк хаяг, банкны аппликейшны нэвтрэх нэр, IP хаяг зэрэг нь тухайн хүний хувийн мэдээлэлд багтана.”



# Хүний эмзэг мэдээлэл болон НУУЦ гэж юу вэ?

Хүний зарим хувийн мэдээлэл нь **ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ** буюу тухайн мэдээллийг задруулсан эсвэл буруугаар ашигласан тохиолдолд тухайн хүнд ноцтой сөрөг үр дагавар учруулж болзошгүй мэдээлэл байдаг. Манай улсын хувьд дараах хүний хувийн мэдээллийг эмзэг мэдээлэлд тооцдог.



Үндэс угсаа	Шашин шүтлэг, итгэл үнэмшил	Эрүүл мэнд	Захидал харилцаа
Генетик ба биометрик мэдээлэл	Тоон гарын үсгийн хувийн түлхүүр	Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх	Бэлгийн ба хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцаа



**Генетик мэдээлэл**  
биологийн сорьцын шинжилгээгээр тогтоосон хүний бие махбод, эрүүл мэнд, өвлөн авсан удамшлын шинж чанарыг илэрхийлсэн дахин давтагдашгүй мэдээлэл  
**Жишээлбэл:** ДНХ



**Биометрик мэдээлэл**  
тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хүнийг тодорхойлох боломжтой гарын хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүр царай, дуу хоолой, биеийн хөдөлгөөний онцлог шинж зэрэг хүний бие махбодтой холбоотой биеийн давхцахгүй өгөгдөл

Хүний **НУУЦ** мэдээлэлд халдсан эсхүл задруулсан тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээнэ. Хүний нууцад дараах мэдээлэл орно: Үүнд:



Эрүүл мэнд



Тоон гарын үсгийн хувийн түлхүүр



Захидал харилцаа



Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл



Генетик мэдээлэл



Бэлгийн харьцааны талаарх мэдээлэл



Биометрик мэдээлэл

**Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.10** дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах гэмт хэрэг  
**13.11** дүгээр зүйл. Хувь хүний нууцыг задруулах гэмт хэрэг

# Хүний хувийн мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах



**Жишээлбэл,** тусгай зөвшөөрөл олгох зорилгоор хүний овог нэр, холбоо барих мэдээлэл, боловсролын мэдээлэл зэрэг хүний хувийн мэдээллийг зөвшөөрөл олгох төрийн эрх бүхий байгууллага иргэнээс авч байгаа нь хүний хувийн мэдээллийг цуглуулж буй хэлбэр юм. Харин тухайн мэдээллийг хүлээн авч шалгаад зөвшөөрөл олгох шаардлагыг хангаж буй эсэхэд дүн шинжилгээ хийж байгаа нь мэдээлэл боловсруулж байгаа хэлбэр юм. Хэрэв зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага дээрх цуглуулсан мэдээллийг бусад төрийн байгууллага руу дамжуулсан тохиолдолд энэ нь мэдээллийг ашигласан явдал болно.

## ОРОЛЦОГЧ ТАЛУУД

**МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН** гэж хэн бэ?

Тухайн мэдээллээр тодорхойлогдож байгаа хувь хүн, зарим иргэний хувьд түүний хууль ёсны төлөөлөгч.

**МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ** гэж хэн бэ?

Хуульд зааснаар эсвэл мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж буй хувь хүн, байгууллага.

**МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧ** гэж хэн бэ?

Мэдээлэл хариуцагчийн өмнөөс мэдээлэл боловсруулж буй этгээд.

**Жишээлбэл,**

**МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН** – Дорж төрийн байгууллагад ажил горилж төрийн албан хаагчийн анкет бөглөж өгсөн. Энэ тохиолдолд Дорж бол мэдээллийн эзэн юм.

**МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ** – Доржийн төрийн албан хаагчийн анкетыг хүлээн авч буй төрийн байгууллага нь мэдээлэл хариуцагч болно.

**МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧ** – Төрийн албан хаагч Дорж томилолтоор Өмнөговь аймагт ажиллах болсон тул түүний ажилладаг төрийн байгууллагаас нь онгоцны билет захиалахаар Доржийн мэдээллийг онгоцны билетийн касс руу дамжуулсан. Энэ тохиолдолд Доржийн мэдээлэлд үндэслэн билет өгч буй онгоцны билетийн касс бол боловсруулагч юм.



# Нийтийн мэдээлэл түүний ангилал ба нийтийн мэдээлэл хариуцагч

“Нийтийн мэдээлэл хариуцагч” гэж дараах этгээдийг ойлгоно.

- Төрийн байгууллага;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд;
- Хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд;
- Олон нийтийн радио, телевиз;
- Улс төрийн нам.

“Нийтийн мэдээлэл” гэж нийтийн мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цуглуулсан, боловсруулсан, ашиглаж байгаа өгөгдлийн бүрдлийг хэлнэ. Нийтийн мэдээллийг 1) нээлттэй, 2) хязгаарлалттай, 3) хаалттай гэж ангилна. Тус ангилал бүрд хамаарах мэдээллийг дор тусгалаа.

## Нээлттэй мэдээлэл

хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй дараах төрлийн мэдээлэл\*:

- ✓ мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт,
- ✓ хүний нөөц,
- ✓ төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа,
- ✓ үзүүлж байгаа үйлчилгээ болон
- ✓ хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээлэл.

## Хязгаарлалттай мэдээлэл

танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээлэл:

- ✓ хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл,\*\*
- ✓ төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл,\*\*
- ✓ нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл,\*\*\*
- ✓ хуульд заасан бусад.\*\*\*

## Хаалттай мэдээлэл


хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээлэл:

- ✓ төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;
- ✓ иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэл;
- ✓ төрийн нууцад хамааруулсан үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл;
- ✓ аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг авахад хөтөлсөн улсын бүртгэлийн мэдээлэл.;
- ✓ хуульд заасан бусад мэдээлэл.

\*Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлээс дэлгэрэнгүй жагсаалтыг харна уу.

\*\*Зөвшөөрөл авахгүйгээр эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна.

\*\*\*Хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна.



# Нээлттэй, ил тод байлгах хүний хувийн мэдээллийн талаар мэдэх нь

Нээлттэй мэдээлэл (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р зүйл)



**Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана. Үүнд:**

- албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг.



**Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана. Үүнд:**

- таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
- цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;
- тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт.



**Хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана. Үүнд:**

- зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.



**Өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана. Үүнд:**

- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны товч, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;
- улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;
- хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн нэр, эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр (Улсын бүртгэлийн тухай хуулийн 12.2.3 дугаар зүйл);
- мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт.

# Төрийн байгууллага хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах харилцаа

Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээлэл **цуглуулж, боловсруулна:**



Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээллийг **ашиглана:**



## АНХААРАХ!

Төрийн байгууллага хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах шаардлага гарах тохиолдолд ямар төрлийн хувийн мэдээллийг, ямар зорилгоор, ямар хуулийн аль заалтад үндэслэн цуглуулж, боловсруулж, ашиглах үндэслэл байгаа эсэхийг шалгах шаардлагатай. Хэрэв хуульд заасан үндэслэл байхгүй л бол мэдээллийн эзнээс **“ЗӨВШӨӨРӨЛ”** авах шаардлагатай.

# Төрийн байгууллага хүний хувийн мэдээллийг хамгаалахад анхаарах 8 асуудал

1

Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах

2

Мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох

3

Хязгаарлалттай мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх

4

Хүний хувийн мэдээлэл дамжуулах

5

Мэдээллийн эзний эрхийг хангах

6

Хүний генетик болон биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах төрийн байгууллага

7

Дүрс бичлэгийн систем ашиглах

8

Хариуцлага



# 1. Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах



Мэдээлэл хариуцагч төрийн байгууллага **хуульд зааснаас бусад үндэслэлээр** мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс **ЗӨВШӨӨРӨЛ** авна.

Түүнчлэн, анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээллийг боловсруулах, ашиглах тохиолдолд мэдээллийн эзнээс **дахин зөвшөөрөл** авах ёстой.



## ЗӨВШӨӨРЛИЙГ ХЭНЭЭС АВАХ ВЭ?

1

**Мэдээллийн эзэн** буюу тухайн мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнээс зөвшөөрлийг авна.

2

**Мэдээллийн эзний хууль ёсны төлөөлөгч** буюу насанд хүрээгүй эсвэл иргэний эрх зүйн чадамжийг нь шүүхээс хязгаарласан хүний мэдээллийг цуглуулахад түүний хууль ёсны төлөөлөгч буюу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрлийг авна.

## ЗӨВШӨӨРЛИЙН ХЭЛБЭР



Мэдээллийн эзнээс зөвшөөрлийг **бичгээр** авна.

## ЗӨВШӨӨРЛИЙГ АВАХДАА ДАРААХ МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛНА. ҮҮНД:

1. мэдээлэл авах зорилго;
2. мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;
3. мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;
4. авах мэдээллийн жагсаалт, мэдээлэл авах хэлбэр;
5. мэдээлэл боловсруулах, ашиглах хүрээ, хадгалах хугацаа;
6. мэдээллийг ил болгох эсэх;
7. мэдээллийг бусдад дамжуулах эсэх;
8. зөвшөөрлөө цуцлах хэлбэр.

Дараах мэдээлэлтэй мэдээллийн эзний зөвшөөрөл авахгүйгээр эрх бүхий этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна. Эдгээр мэдээлэл нь:



- Хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;



- төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл.

## АНХААРАХ!

- Зөвшөөрөл авахыг шаардаагүй дээрх хоёр үндэслэлээс бусад тохиолдолд хүнд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл **МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРЛӨӨР** л төрийн байгууллага цуглуулж, боловсруулж, ашиглана.
- Мэдээлэл цуглуулж буй зорилгын дагуу зөвхөн хуульд заасан хэмжээнд **зайлшгүй шаардлагатай** мэдээллийг л цуглуулж авна.



## 2. Мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох

### Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох

Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүнд хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулж, **нээлттэй өгөгдөл** болгож болно.

Нээлттэй өгөгдлийг мэдээлэл хариуцагч өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.


Нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрийн боловсруулсан нээлттэй өгөгдлийг **тогтмол шинэчилж** байх үүрэгтэй.



### Дараах тохиолдолд нээлттэй өгөгдлийг нийтлэхийг хориглоно:




- тухайн нээлттэй өгөгдлөөр дамжуулан хүнийг тодорхойлох боломжтой бол;



- тухайн нээлттэй өгөгдлийг нийтэлснээр хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөр бол.

### АНХААРАХ!

Хүний хувийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох тохиолдолд хүнийг тодорхойлох боломжгүй болгох ёстой.



### 3. Хязгаарлалттай мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх



Хүн, хуулийн этгээд хязгаарлалттай мэдээллийг (*танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон хүнд хамаарах мэдээлэл*) бичгээр хүсэлт гаргаж авч болно.

Бичгээр гаргасан хүсэлтэд тусгах мэдээлэл



- хүсэлт гаргагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр;
- хүсэлт гаргагчийн оршин суугаа, эсхүл оршин байгаа газрын хаяг, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар;
- **хязгаарлалттай мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, мэдээллийн эзний зөвшөөрөл;**
- мэдээллийн агуулга, мэдээлэл хүлээн авах хэлбэр.

#### Төрийн байгууллагаас мэдээлэл авах хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх ажиллагаа

Хүсэлтийг хүлээн авах

Бүртгэл хөтлөх

Хүсэлтийг хүлээн авч мэдээллээр хангах

Хүсэлтийг холбогдох мэдээлэл хариуцагчид шилжүүлэх

Хүсэлтийг буцаах

**Дараах мэдээллийг бүртгэлд тусгана. Үүнд:**

- хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, харилцах утасны дугаар, хаяг;
- хүссэн мэдээллийн товч агуулга;
- хүсэлт хүлээн авсан, мэдээлэл өгсөн он, сар, өдөр, хэлбэр;
- хүсэлтийг буцаасан тохиолдолд буцаасан үндэслэл, хэлбэр;
- мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн өгсөн эсэх;
- шаардлагатай бусад.

**Дараах тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Үүнд:**

- Хүсэлт нь хуульд заасан шаардлагыг хангаагүй;
  - Урьд өмнө хариу өгсөн асуудлаар дахин хандсан;
  - Хүсэлтэд дурдсан мэдээлэл байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй
- Буцааж буй үндэслэлийг тодорхой заах шаардлагатай.**

#### АНХААРАХ!

- Хуульд хаалттай эсхүл ил тод байхаар заагаагүй хүний хувийн мэдээлэл нь хязгаарлалттай мэдээлэлд орно.
- Хязгаарлалттай мэдээллийг хувь хүн эсхүл хуулийн этгээд авах хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн эзний зөвшөөрлийг хавсаргасан байна.



## 4. Хүний хувийн мэдээлэл дамжуулах

Төрийн байгууллага хүний хувийн мэдээлэл дамжуулахдаа юуг анхаарах вэ?



- Төрийн байгууллага болон **хуульд заасан** бусад этгээд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан **үндэслэл, журмын дагуу** хүний хувийн мэдээллийг (хязгаарлалттай мэдээлэл) ашиглах бол мэдээллийн эзний **зөвшөөрөл шаардахгүй**.
- Дээрхийн дагуу мэдээлэл хариуцагч мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан бол мэдээллийн эзэнд энэ талаар **мэдэгдэл** хүргүүлнэ.

Жишээ маягт

МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭНД ХҮРГЭХ МЭДЭГДЭЛ				
Мэдээлэл хариуцагч байгууллага	Мэдээлэл ашигласан байгууллага	Үндэслэл (хуульд заасан, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрсөн)	Дамжуулсан мэдээлэл	Огноо

*\*Танд тодруулах зүйл байвал мэдээлэл ашигласан байгууллагад хандана уу.*

Мэдээлэл хариуцагч хязгаарлалттай мэдээллийг ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтөлнө.




**Бүртгэлд дараах мэдээллийг тусгана. Үүнд:**

- хүсэлт гаргасан этгээдийн мэдээлэл;
- мэдээллийг өгсөн, дамжуулсан он, сар, өдөр;
- мэдээллийн эзнийг тодорхойлох мэдээлэл;
- мэдээллийн эзний зөвшөөрөл шаардахаар хуульд заасан тохиолдолд түүний зөвшөөрөл өгсөн хэлбэр;
- зөвшөөрлийн баталгаажуулалт хийсэн он, сар, өдөр;
- хүсэлт гаргагчийг цахим тодорхойлогчоор тогтоосон тодорхойлолт;
- байгууллага, албан тушаалтны хандсан он, сар, өдөр;
- авсан мэдээллийн агуулга;
- мэдээлэл авсан зорилго;
- мэдээлэл ашигласан этгээд нь хувь хүн бол эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, албан тушаалтны эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, харилцах утасны дугаар;
- мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн өгсөн эсэх;
- өгсөн, дамжуулсан мэдээллийн жагсаалт, мэдээлэл авсан хэлбэр;
- хуульд заасан бусад этгээд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний хувийн мэдээллийг дамжуулсан тохиолдолд тухайн мэдээллийг авах хууль зүйн үндэслэл.

### АНХААРАХ!

- Хязгаарлалттай мэдээллийг гүйцэтгэх ажлын хүрээнд эрх бүхий байгууллагад дамжуулсан бол энэ зохицуулалт үйлчлэхгүй.



## 5. Мэдээллийн эзний эрхийг хангах

Мэдээллийн эзэн өөрийн эдлэх дараах эрхийн хүрээнд хүсэлт гаргах боломжтой ба мэдээлэл хариуцагч хүсэлтэд хариу өгөх үүрэгтэй юм.

### МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЭРХҮҮД

Мэдээлэл өгөхөөс татгалзах

Хувийн мэдээллээ мэдэх

Хувийн мэдээллийг нь цуглуулсан, боловсруулсан, ашигласан эсэхийг мэдэх

Мэдээллийг хуулийн дагуу цуглуулахыг хориглосон, устгах ёстой тохиолдолд хэрэгжүүлэхийг шаардах

Мэдээллээ устгуулах буюу мартагдах

Мэдээллээ дамжуулах

Хувийн мэдээллийг дамжуулсан талаар болон, хүлээн авсан этгээдийн талаар мэдэх

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад цуцлах хүсэлт гаргах

Мэдээлэл цуглуулах, дамжуулах зөвшөөрлийг өгөх, өгөхөөс татгалзах

Мэдээллээ залруулах

Хувийн мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас гаргуулан авах

Мэдээллийг боловсруулсны үр дүнд гарсан шийдвэрт гомдол, тайлбар гаргах



### ХҮСЭЛТЭД ХАРИУ ӨГӨХ АЛХМУУД

 **Мэдээллийн эзнийг тодорхойлох.** Цахим орчинд эсвэл иргэний үнэмлэх, адилтгах бичиг баримтаар мэдээллийн эзэн (хууль ёсны төлөөлөгч) мөн эсэхийг баталгаажуулна.

 **Хүсэлтийг шийдвэрлэх.** Мэдээллийн эзэн (хууль ёсны төлөөлөгч) мөн болох нь тогтоогдсон тохиолдолд хүсэлтийг нь холбогдох ажилтан, хэлтэст дамжуулж шийдвэрлэнэ. Мэдээллийн эзний хүсэлтийг биелүүлэх боломжгүй бол яагаад татгалзаж байгаа хуулийн үндэслэлийг заана.

 **Хүсэлтийн хариуг баримтжуулах.** Мэдээллийн эзний хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн талаар бүртгэлд тэмдэглэнэ.

### АНХААРАХ!

**Мэдээллийн эзний мэдээллээ устгуулах (мартагдах) хүсэлтийг шууд хүлээн авч устгаж болох уу?**

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хүний хувийн мэдээллийг устгах нөхцөлийг заасан тул иргэний мэдээллээ устгуулах хүсэлт хүлээн авсан тохиолдолд хуульд заасан нөхцөл байгаа эсэхийг шалгана. Хуульд тусгайлан хадгалахаар заасан, хадгалах хугацаа тогтоосон мэдээлэл эсэхийг нягталсны үндсэн дээр мэдээллийн эзэнд хариу өгнө.

## 6. Хүний генетик болон биометрик мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах төрийн байгууллага

Төрийн байгууллага зөвхөн дараах зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний генетик болон биометрик мэдээллийг цуглуулж, ашиглана:



### Улсын бүртгэл

Улсын бүртгэлийн байгууллага иргэний улсын бүртгэл хөтлөх, сонгогчийн бүртгэлийг хянах зорилгоор биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/ цуглуулж ашиглана.



### Хил хамгаалах байгууллага

Хил хамгаалах байгууллага улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэнийг таних, баталгаажуулах зорилгоор биометрик мэдээлэл цуглуулж ашиглана.



### Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх

Хуульд заасан эрх бүхий байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор генетик болон биометрик мэдээлэл цуглуулж ашиглана.



### Шүүхийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шинжилгээ хийхэд генетик болон биометрик мэдээллийг цуглуулж ашиглана.



### Улсын Их Хурал

Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор биометрик мэдээллийг цуглуулж ашиглана.

Мэдээлэл хариуцагч генетик болон биометрик мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагаандаа мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. Үүнд дараах арга хэмжээ хамаарна.



- 01 Мэдээллийн аюулгүй байдлыг хангах **дотоод журам** баталж үйл ажиллагаандаа мөрдөх;
- 02 Мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх **төлөвлөгөөг** батлах;
- 03 Ашиглаж буй мэдээллийн технологийн **системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг** хангах арга хэмжээ авах;
- 04 Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар **журам, зааварчилгаа** баталж, мөрдөх;
- 05 Мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны **аюулгүй байдлыг хангах зорилгоор үнэлгээг** хийх.

# 7. Дүрс бичлэгийн систем ашиглах

## ДУУНЫ, ДҮРСНИЙ, ДУУ-ДҮРСНИЙ БИЧЛЭГИЙН СИСТЕМ ГЭЖ ЮУ ВЭ?



Технологийн тусламжтайгаар **дуу, дүрс, дуу-дүрсний мэдээлэл** цуглуулах, дамжуулах, хадгалдаг техник хэрэгсэл, тэдгээр мэдээллийг дамжуулах хадгалах сүлжээ, төхөөрөмж, программ хангамжийг ойлгоно. **Жишээлбэл**, бидний сайн мэдэх камер нь дүрс бичлэгийн төхөөрөмж юм.



### Дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж болох тохиолдол:

- Нийтийн зориулалттай орон сууцны орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайд аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор;
- Ажлын байранд мэдээллийн аюулгүй байдлыг, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор.



### Дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийхийг хориглосон байршил:

- Ариун цэврийн өрөө;
- Хувцас солих өрөө;
- Нийтийн үйлчилгээний газрын тусгай зориулалтын үйлчилгээний өрөө;
- Караокены өрөө;
- Зочид буудлын өрөө;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх хэвтүүлэн эмчлэх өрөө;
- Бусад хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд;
- Нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан;
- Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөх.



Хориглосон байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан бол **ГЭМТ ХЭРЭГ**. (Эрүүгийн хууль 13.8.4)

Хориглосон байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулсан бол **ЗӨРЧИЛ**. (Зөрчлийн тухай хууль 6.22.4)

Хүний эрхийн Үндэсний Комиссоос хууль хяналтын байгууллагатай хамтран дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор шалгалт хийх эрхтэй.

### АНХААРАХ!

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахтай холбогдсон харилцааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.



## 8. Хариуцлага

- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд **Эрүүгийн хууль**, эсхүл **Зөрчлийн тухай хуульд** заасан хариуцлага хүлээлгэнэ.
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол **Төрийн албаны тухай хууль**, эсхүл **Хөдөлмөрийн тухай хуульд** заасан хариуцлага хүлээлгэнэ.



### Эрүүгийн хууль

#### 13.8. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах

- Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх болон орох гарах хэсгийг хамруулан орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол.
- Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, бусдад дамжуулсан бол.

**Торгох ял /450,000 – 2,700,000 төгрөг/**

**Нийтэд тустай ажил хийлгэх ял**

**Хорих ял**

**(аль нэгийг ногдуулна)**

#### 13.10 дугаар зүйл.Хувь хүний нууцад халдах

- Хувь хүний хуулиар хамгаалагдсан **нууцыг** хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол.

#### 13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах

- Хувь хүний хуулиар хамгаалагдсан **нууцыг** олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол.

**ХҮНДРҮҮЛЭХ** нөхцөл:

- харилцаа холбоо, цахим сүлжээ ашигласан бол.
- албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол.

**Торгох ял /450,000 – 27,000,000 төгрөг/**

**Нийтэд тустай ажил хийлгэх ял**

**Зорчих эрхийг хязгаарлах ял**

**Хорих ял**

**(аль нэгийг ногдуулна)**



### Зөрчлийн тухай хууль

#### 6.22 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх

- Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн бол.
- Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад үзүүлсэн, эсхүл хуулбарлаж өгсөн бол.
- Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн бол.

**ТОРГУУЛЬ**

**200,000 – 8,000,000 төгрөг**

#### 6.27 дугаар зүйл.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих

- Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авсан зорилгоос өөр зорилгоор хүний хувийн мэдээллийг ашигласан бол.
- Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлсэн бол.
- Хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан бол.

**ТОРГУУЛЬ**

**500,000 – 20,000,000 төгрөг**

# ХУРААНГУЙ ЗӨВЛӨМЖ

## ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

### Мэдээллийн эзний зөвшөөрөл

Хуульд заасан үндэслэл байхгүй л бол хүний хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, боловсруулахдаа мэдээллийн эзний зөвшөөрлийг бичгээр авах ёстой.

### Зөрчлийн бүртгэл хөтлөх

Мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтлөх ба тус бүртгэлээ ХЭҮК-т жил бүрийн 1-р сард хүргүүлэх үүрэгтэй.

### Зорилгодоо нийцсэн мэдээлэл авах

Хуульд заасан үндэслэлээр хүний хувийн мэдээллийг авах тохиолдолд зөвхөн шаардлагатай мэдээллийг авах ёстой. Мөн, хүний хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй бусдад дамжуулахгүй, ил болгохыг хориглосныг анхаарах.

### Мэдээллийг задруулахгүй байх

Мэдээллийг хуульд заасан үндэслэлээр дагуу олж мэдсэн этгээд зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно. Хувь хүний нууцыг задруулсан тохиолдолд энэ нь гэмт хэрэг болно.

### Ажилтны цагийн бүртгэл

Хурууны хээгээр бүртгэл хийх хориотой. Ажилтныг таних болон баталгаажуулахад хурууны хээнээс бусад биометрик мэдээллийг ашиглаж болох ч энэ нь нууц мэдээлэл тул ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.

### Өөр зорилгоор ашиглах

Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор боловсруулах, ашиглахыг хориглоно. Өөр зорилгоор ашиглах, боловсруулах тохиолдолд дахин зөвшөөрөл авах ёстой.

### Ажлын байрны дүрс бичлэг

Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд ажлын байранд зөвхөн мэдээллийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүднээс дүрс бичлэг хийх бөгөөд анхааруулга байршуулах ёстой. Ажлын гүйцэтгэлийг дүрс бичлэгээр хянахгүй.

### Хяналт

Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс хяналт тавина.

